



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Монгол Улсын Их Сургууль
Хэрэглээний Шинжлэх Ухаан Инженерчлэлийн Сургууль

Сургалтын хөтөлбөрийн нэр: Мэдээллийн систем

Индекс: D061303

Шинжээчийн баг:

Ахлагч: Ц.Ганбат
Гишүүд: Б.Баянмөнх
А.Золзаяа

Он сар өдөр: 2018 оны 12-р сарын 10

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Магадлан шинжлэх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Мэргэжлийн зөвлөлийн тодорхойлолт

IV. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 3: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 4: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 5: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 6: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 7: Хөтөлбөрийн үр дүн, үр нөлөө

Шалгуур 8: Чанарын үнэлгээ, баталгаажилт

V. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс

IV. Төгсөгчдийн нэрс

VI. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VII. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VIII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
БМИҮЗ	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл
МУИС	Монгол улсын их сургууль
ШУТИС	Шинжлэх ухаан технологийн их сургууль
МХТС	Мэдээлэл харилцаа технологийн сургууль
АШУҮИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
МТА	Мэдээлэл технологийн алба
ХХМТГ	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар
ШУТС	Шинжлэх ухаан технологийн сан

I. Магадлан шинжлэх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Монгол Улсын Их Сургууль, Хэрэглээний Шинжлэх Ухаан, Инженерчлэлийн Сургууль, Мэдээлэл, Компьютерийн Ухааны Тэнхим National University of Mongolia	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Мэдээллийн Систем Information System	
Индекс	D061303	
Шинжээчид	Ахлагчийн нэр, ажил, албан тушаал: 1. Ц.Ганбат. ШУТИС, МХТС-ийн профессор Гишүүдийн нэр, ажил, албан тушаал: 2. Б.Баянмөнх АШУҮИС, МТА-ны дарга 3. А.Золзаяа ХХМТГ-ын хэлтсийн дарга	
БМИҮЗ-ийн мэргэжилтэн	Нэр, албан тушаал:Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн Б.Оюунчимэг	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2018.11.20	Шинжээчид гэрээ байгуулах
	2018.11.27	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайлан гаргах
	2018.11.29-30	Сургууль дээр ажиллах
	2018.12.10	Үнэлгээний тайланг мэргэжилтэнд өгөх
	2018.12.19	Сургуулиас ирсэн албан бичигтэй танилцан үнэлгээний тайланг эцэслэн боловсруулж мэргэжилтэнд өгөх
	12 сард	Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанд танилцуулах

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Мэдээллийн систем хөтөлбөрийг 2001 онд баталж, сургалт эхлүүлсэн ба анхны төгсөлтийг 2005 онд хийсэн байна. Хөтөлбөрөөр 13 удаа төгсөлт хийсэн ба энэ хичээлийн жилд 136 оюутан суралцаж байна.

Хөтөлбөрийг 2009, 2010, 2012, 2013, 2015 онуудад шинэчилж боловсронгуй болгосон байна. Хөтөлбөр нь анх удаа магадлан итгэмжлэлд орж байгаа бөгөөд тэнхимийн хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багийн зүгээс олон улсын магадлан итгэмжлэлд орохоор зорин ажиллаж байна.

Мэдээллийн системийн хөтөлбөрийн зорилго:

Байгууллагын мэдээллийн хэрэгцээг тодорхойлон мэдээллийн технологийг ашиглан, мэдээллийн системийг автоматжуулах шийдлийг боловсруулах, бүтээх үйл ажиллагааг удирдах, оролцох, нийгэмд үйлчлэх мэдлэг, чадвартай иргэний өндөр ухамсар, соёлтой мэргэжилтэн бэлтгэх.

Мэдээллийн системийн хөтөлбөрийн зорилт:

1. *Сургалтын хөтөлбөр зорилго, бодлого төлөвлөлтийн талаар:* Сургалтын хөтөлбөрийг олон улсын байгууллагуудаас гаргасан зөвлөмж, стандартад нийцүүлэх, бэлтгэн гаргаж буй мэргэжилтний чанарыг улам сайжруулах, зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, сургалтын кредит тогтолцоо болон шавь төвтэй сургалтад шилжих, сургалтад дэвшилтэт арга технологиудыг нэвтрүүлэх, бакалавр магистр докторын шаталсан сургалтуудын уялдаа холбоог улам сайжруулах.
2. *Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч хүний хүчин зүйлсийн талаар:* Бакалаврын сургалттай холбоотой журам, заавруудыг шинэчлэх, шинээр боловсруулах мөрдөх, багшлах боловсон хүчний хангамжийг сайжруулах, багш бэлтгэх тогтолцоог бүрдүүлэх, багш бүр оюутны туслагч, хамтран ажиллагч, тэдний идэвх санаачилга, авьяасыг хөгжүүлэгч байх, багшлах боловсон хүчний чанарыг дээшлүүлэх, суралцагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, бие даан ажиллах чадварыг байнга дээшлүүлэх, төгсөгчид суралцагчдын хамтын ажиллагааг хөгжүүлэх.
3. *Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх материаллаг орчин, нөөцийн талаар:* Мэргэжлээр суралцах үндэсний сурах бичгийн хангамжийг нэмэгдүүлэх, мэдээллийн системийн мэргэжлийн суурь хичээлүүдээр гаргасан гадаад дотоодын шилдэг сурах бичгийг худалдан авах, сургалтанд ашиглах, сургалтын лабораториудыг шинэчлэх, шинээр байгуулах

III. Шинжээчийн багийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1 Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ хийсэн байдал
- Төгсөгчийн /мэргэжилтний/ загвар
- Хөтөлбөрийг индексийн хувьд ижил салбар, чиглэлийн гадаад дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулсан байдал /ялгаатай, давуу, сул тал, сайжруулалт/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Олон улсын жишигт нийцсэн
- Мэргэжлийн суурь хичээлүүдийн багц ижил төстэй гадны их дээд сургуулиудын хөтөлбөрийн хичээлүүдийн агуулгатай нийцэж байна.
- Мэргэжилтний нийгэм дэх хэрэгцээ шаардлагыг олон улсын болон дотоодын судалгааг харьцуулан хэрэгцээ шаардлага өндөр байгааг тодорхойлжээ.

Анхаарах асуудал:

- Хичээл хоорондын агуулгын уялдаа холбоог сайжруулах

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн хувьд чадварлаг оюутан эрт төгсөх боломжийг олгох хэрэгтэй. Хөтөлбөрт эхний 1-2 жилд дээд боловсролын суурь хичээлүүд зонхилж байна. Мэргэжлийн суурь хичээлийг эхний улирлаас эхлэн зааж эхэлбэл зохимжтой.

1.2 Хөтөлбөрийн үзэл баримтлал, зорилго

Хөтөлбөрийн үзэл баримтлал тодорхой; төгсөгчийн эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, хандлага нь мэргэжлийн салбарын хөгжил, зах зээлийн эрэлтэд нийцсэн байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримталж байгаа үзэл баримтлал, сургалтын арга зүй, тогтсон үнэлгээний систем

- Хөтөлбөрийн хүрэх үр дүн, онцлог, сургуулийн эрхэм зорилго, зорилттой нийцсэн байдал
- Төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлоход оролцогч, сонирхогч талуудын саналыг тусгаж, хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт төлөөллийг оролцуулсан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн шинэчлэлтийг олон улсын байгууллагын зөвлөмж (ACM&AIS IS 2010 Curriculum Guidelines) болон төр засгийн бодлогод нийцүүлэн шинэчилсэн.
- Зах зээлийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан хичээлийн хөтөлбөрт шаардлагатай хичээлүүдийг сургалтын хөтөлбөртөө нэмж тусгасан байна.
- Хөтөлбөрийн зорилго зорилтыг тодорхойлохдоо ажил олгогч байгууллагуудын хүсэл сонирхлыг эрхэмлэж үздэг.
- Төгсөгчид хөдөлмөрийн зах зээлд өөрсдийн брэндийг таниулсан.

1.3 Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга; сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй; сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тогтмол тусган сайжруулдаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг хангаж, баталгаажуулсан байдал
- Сургалтын төлөвлөлт нь онол, практикийг зохистой хослуулсан, суралцагчийн мэргэжлийн болон хувь хүний ур чадваруудыг хөгжүүлэхэд чиглэсэн байдал
- Хичээлийн хөтөлбөр нь хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, агуулга, ур чадварын хувьд харилцан залгамж холбоотой, сургалтын арга зүйн болон үнэлгээний олон талт арга, хэлбэрийг тусгасан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам бүрэн боловсруулагдсан.
- Хичээлийн хөтөлбөрийн агуулгын шинэчлэлийг багш бүр шинэчлэн хийж байна.

Анхаарах асуудал:

- Агуулгын шинэчлэл хийсэн тохиолдолд хөтөлбөрийн хороогоор хэлэлцүүлж албажуулах

Зөвлөмж:

- Зарим мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээлийн лабораторийн удирдамжийг боловсруулж, тэнхимийн багш нараар хэлэлцүүлж батлуулах
- Багш нарыг мэргэжлийн ном сурах бичиг бичихэд сургуулийн зүгээс дэмжлэг, тусалцаа үзүүлэх

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн эсэхэд дүгнэлт хийх

2.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Эрүүл, аюулгүй, тохилог орчинг бүрдүүлсэн байдал
- Тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, лаборатори, урлангийн хангалт, ашиглалтын байдал
- Бие даан болон багаар ажиллах орчны хангалт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага

- Лекцийн 6 танхим нь 357 суудалтай нийт 359м² талбайтай, семинарын 8 танхим нь 247 суудалтай нийт 250м² талбайтай, 155 компьютертэй 9 лаборатори сургалтандаа ашиглаж байна.
- Оюутны сургалтын орчны талаар сэтгэл ханамжийн судалгааг SiSi системээр хичээл тус бүрээр улирал тус бүр гаргадаг. Судалгааны үр дүнг үндэслэн сургалтын орчин нөхцөлийг сайжруулдаг.
- Орчин үеийн техник, технологи бүхий судалгааны 3 лабораторийг сургалтандаа ашиглаж байна.
- Багш, оюутан SiSi систем ашиглаж хэвшсэн.

Зөвлөмж:

- SiSi системээ үргэлжлүүлэн хөгжүүлэх. Үүнд тэнхимийн багш нарын ажлын тайлан болон цагийн тооцоог гаргадаг болох, төгсөх оюутны дипломын ажилтай холбоотой ажлыг хөтлөх

2.2 Сургалтын хэрэглэгдэхүүн, хэрэгсэл

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Программ хангамж, симуляци, виртуал лабораторийн хэрэглээ, хүртээмж
- Хичээл практикийн материаллаг нөөц, хэвлэмэл үзүүлэн, тараах материал, хэрэглэгдэхүүний хүртээмж, хэрэглээ
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмжийн хүртээмж

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтад 24 төрлийн 42 программ хангамж ашигладаг.
- Сургалтад лицензтэй программ хангамж хэрэглэдэг.
- Багш бүр сургалтад ашиглагддаг лабораторийн удирдамж, бодлого дасгал зэргийг оюутнуудад хэвлэмлээр болон цахим хэлбэрээр SiSi системээр дамжуулан хүртээдэг.

Анхаарах асуудал:

- Мэдээллийн систем мэргэжил бол бүртгэлийн ажлыг хурдасгах төрөл бүрийн төхөөрөмж ашигладаг. Гэтэл оюутнууд ашиглах, багш нар лекцэд танилцуулах биет төхөөрөмж дутагдалтай байгааг анхаарах хэрэгтэй. Үүнд бар код уншигч, карт уншигч, хэвлэгч, light pen, мобайл болон таблет төхөөрөмж, камер, биометрикийн төхөөрөмжүүд

Зөвлөмж:

- Лабораториудаа шинэчлэх
- Шаардлагатай төхөөрөмжүүдээр хангах

2.3 Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт мэдээллээр тогтмол, чанартай хангадаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн судалгаа, хүртээмж, хэрэглээ
- Виртуал, дижитал видео, аудио болон бусад цахим эх үүсвэрүүдийн байдал
- Цахим орчны хүртээмж, хэрэглээ
- Сургалт, судалгааны лицензтэй программын ашиглалтын байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Номын мэдээллийг хайх электрон каталогитой, хөтөлбөртэй холбоотой 1500 гаруй сурах бичиг, номтой. Зарим номыг цахимаар унших боломжтой.
- Мэргэжлийн сурах бичгийн 80 гаруй хувь нь англи хэл дээр байна.

- Олон улсын нээлттэй эхийн 9 мэдээллийн санг сургалт болон судалгааны үйл ажиллагаанд ашиглаж байна.
- IEEE санг төлбөртэйгээр сургалт болон судалгааны үйл ажиллагаанд ашиглаж байна.
- Цахим сургалтандаа OpenEdx болон Mooc системийг ашиглаж байна.
- 200 ширхэг лицензтэй Windows үйлдлийн систем, Microsoft Office програмуудыг худалдаж авч ашиглаж байна.

Анхаарах асуудал:

- Сургалтад ашиглаж буй сурах бичгийн цөөхөн хувийг монгол хэл дээрх сурах бичиг эзэлж байна.

Зөвлөмж:

- Сургалтыг материаллаг орчныг бүрдүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх.
- Багш нараар мэргэжлийн ном сурах бичиг орчуулж, бичүүлж монгол хэл дээрх мэргэжлийн ном сурах бичгийн тоог нэмэгдүүлэх

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

3.1 Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалт, хяналт, ил тод байдал
- Хөтөлбөрийн нэгжийн /тэнхим, профессорын баг, хөтөлбөрийн хороо/ шийдвэр гаргалт, хэрэгжилтийн үнэлгээнд багш, суралцагчдын оролцоог нээлттэй, ил тод хангасан байдал
- Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхэд шаардлагатай дүрэм, журмуудын хэрэгжилт
- Урт болон богино хугацааны төлөвлөлт, гүйцэтгэлийн тайлан, ахиц өөрчлөлтийн дүн шинжилгээ механизм
- Санал, гомдол хүлээн авах, хариу өгөх үйл ажиллагаа, систем бүрдсэн байна.
- Хөтөлбөрийн багш, ажилтнуудын хүний нөөцийн судалгаа, шинжилгээ, хөгжүүлэх ажлын үнэлгээ, гүйцэтгэлийн болон үр дүнгийн урамшууллын хэрэгжилт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- SISI систем ашиглан багш, оюутны эрхээр орж сургалтын үйл ажиллагаатай холбоотой мэдээллээ хоорондоо дамжуулдаг, хардаг, солилцдог зэрэг олон боломжтой үйлдэлтэй систем байна.
- Багш нарт эрдэм шинжилгээ, судалгааны грант олгодог
- Багш нарын эрдэм шинжилгээний ажлыг үнэлэх дүрэм журам боловсруулсан, түүнийгээ мөрддөг, хэвшсэн.

Зөвлөмж:

- Багш нарын эрдэм шинжилгээний бүтээлийг бүртгэж бүтээлийн вебсайтаа нийтэлдэг бол зохимжтой.

3.2 Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөдөлмөрийн зах зээлийн тандан судалгааны давтамж
- Хөтөлбөрийн сурталчилгаа, идэвхжүүлэлтийн арга хэлбэр, хүртээмж, үр нөлөө

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2024 он хүртэлх стратеги төлөвлөгөөтэй.
- 2013 оноос эхлэн хөтөлбөр сурталчлах өдөрлөгийг МУИС-ийн хэмжээнд хичээлийн жилд 2 удаа тогтмол зохион байгуулдаг. Хөтөлбөр сурталчлах өдөрлөгийн үр дүнд мэдээллийн систем хөтөлбөрт элсэх хүсэлт гаргасан оюутны тоо жил бүрийн хяналтын тооноос их байна.
- Мэдээллийн систем хөтөлбөр сонгон суралцаж буй оюутнуудын дунд жил бүр эрдэм шинжилгээний хурал зохион байгуулдаг
- МУИС-д элсэн суралцсан тохиолдолд хамрагдах боломжтой тэтгэлэгт хөтөлбөрүүдийн талаар элсэгчдэд сурталчилдаг

Анхаарах асуудал:

- Өөрсдийн хэрэгжүүлж буй бусад хөтөлбөрүүдээс ялгагдах онцлогийг илүү тодорхой гаргаж өгөх, элсэгч болон ажил олгогчидод сурталчилах

3.3 Төгсөлтийн дараах бодлого

Хөтөлбөр нь төгсөгчидтэйгээ байнгын эргэх холбоотой, тэдний мэргэжлийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулж, төгсөгчид нь суралцаж буй суралцагчдад мэргэжлийн чиглэлээр ажиллахад нь зөвлөн тусалдаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Төгсөгчдийн карьерын өсөлтийн судалгаа

- Үргэлжлүүлэн суралцагчдын хувь хэмжээ
- Төгсөгчдийг давтан сургалтад хамруулах бодлого, төлөвлөгөө, хамрагдсан байдал
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны тогтмолжсон байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2004 оноос хойших төгсөгчдөөс төгсөгч мөшгөх судалгааг сүүлийн 2 жилд тогтмол хийсэн.
- Судалгаанд хамрагдсан төгсөгчдийн 85% нь төгсөөд шууд ажил эрхэлсэн.
- Нийт төгсөгчдийн 18.2% нь мэдээлэл технологи, мэдээллийн систем, компьютерийн ухааны чиглэлээр гадаадын их дээд сургуульд үргэлжлүүлэн суралцаж байна.
- Мэдээллийн Технологи Шинжлэх Ухааны Парктай хамтран дэлхийн 12 оронд хүлээн зөвшөөрөгдсөн мэдээллийн технологийн суурь шалгалтад бэлтгэх сургалтыг төгсөгчдөд зориулан зохион байгуулдаг.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн холбоо байгуулах
- Төгсөгчдөө давтан сургах бодлоготой болох

Зөвлөмж:

- Төгсөгчдөөс судалгаа авч мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулах

3.4 Олон улсын харилцаа, хамтын ажиллагаа

Олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагуудтай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хэрэгжүүлж буй хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн тайлан, дүгнэлт
- Багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоо
- Олон улсын хурал семинар, судалгаа болон бусад арга хэмжээнд оролцсон тоо, үр дүн, ач холбогдол

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Олон улсын 10 гаруй байгууллагатай байнгын хамтын ажиллагаатай ажилладаг
- Хөтөлбөрт суралцаж буй оюутнууд хамтын ажиллагаатай 10 сургуульд солилцоогоор суралцах боломжтой.
- Багш нар хамтарсан төсөл хэрэгжүүлж байна.

3.5 Дотоод хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нь мэргэжлийн холбоод, үйлдвэр, үйлчилгээний байгууллагууд, ажил олгогч эздийн холбоо, төрийн болон ТББ-уудтай хамтран ажилладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хамтран ажиллах гэрээ, хэлцэл, ажлын үр дүн
- Хэрэгжүүлж буй ажлуудын тайлан, дүгнэлт
- Хамтын ажиллагааны арга, туршлага
- Нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоо үр дүн /багш, суралцагчдын зүгээс/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Мэдээлэл технологийн шинжлэх ухааны паркттай хамтран Мэдээлэл технологийн шалгалт боловсруулах үндэсний зөвлөлд ажилладаг.
- Дунд сургуулийн сурагчдын мэдээлэл зүйн олимпиадыг ШУТИС, МУБИС-тай хамтран жил бүр зохион байгуулдаг.
- Дотоодын байгууллагуудтай эрдэм шинжилгээний болон үйл ажиллагаанд нь зөвлөгөө өгөх зарчмаар хамтран ажилладаг.

Зөвлөмж:

- Багш болон оюутныг мэдээллийн технологийн олон улсын инженерийн суурь шалгалтад хамруулах

3.6 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Төсөв, санхүүгийн бие даасан байдлын хөгжил
- Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв
- Төр хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалт
- Төсвийн уламжлалт бус эх үүсвэр, бүрдүүлэлт, хуваарилалт, санхүүжилт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Санхүүгийн эх үүсвэр тогтмол
- Ерөнхий суурь эрдмийн хичээлийн 1 багц цагийн төлбөр 98,600 төгрөг, мэргэжлийн хичээлийн 1 багц цагийн төлбөр 103,500 төгрөг

- МУИС-ийн төсвийн 78,7% нь оюутны сургалтын төлбөр, 7% нь улсын төсвийн санхүүжилт, 14,3% нь үндсэн бус үйл ажиллагааны орлогоос бүрддэг.
- 2015 оны төсөвт дотоод, гадаадын магадлан итгэмжлэлд зориулж 205 сая төгрөгийг суулгасан.
- Хөтөлбөрт зарцуулах төсөв сүүлийн 5 жилд жигд өсөлттэй байна.
- Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 70 сая төгрөгийн өртөг бүхий компьютер, графикийн иж бүрэн лаборатори, Unimedia компанийн тусламжаар програм хөгжүүлэх 20 сая төгрөгийн өртөг бүхий лаборатори
- Сургалтын тэтгэлэг, урамшуулал төсвөөс санхүүждэг.

Анхаарах асуудал:

- Төсвийн эх үүсвэр сургалтын төлбөрөөс хамаарч байна.
- Төсвийн зарцуулалтыг тайланд бүрэн тусгаагүй байна.

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

4.1 Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Суралцагч элсүүлэх эрх зүйн зохицуулалтад хөтөлбөрийн онцлогт нийцсэн шалгуурыг тусгасан байдал
- Элсэгчдийн ЕШ-ийн дундаж оноо, хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцаа
- Шинээр элссэн суралцагчдыг чиглүүлэх сургалтад хамруулж, мэдээлэл, гарын авлагаар хангасан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн захирлын 2016.02.19-ны А/38 тоот тушаалаар элсэлтийн журмыг жил бүр шинэчлэн баталдаг. МУИС-ийн албан ёсны элсэлтийн веб хуудсаар элсэлттэй холбоотой дүрэм журам, мэдээллийг хүргэдэг.
- Элсэхийг хүсэгчдийн тоо жилээс жилд өсөж байна.
- 2017 оноос хөтөлбөрөөр элсэгчдийн шалгуур үзүүлэлтэд Физикийн хичээл нэмэгдэж, элсэгчдийн дундаж оноо нь Математик 600, Физик 520 байна.
- Шинээр элссэн суралцагчдыг бүрэлдэхүүн сургуулийн сургалтын алба болон тэнхим хамтран чиглүүлэх сургалтыг зохион байгуулдаг.

- Шинээр элсэгчдэд Сиси системээр дамжуулан суралцах зөвлөмжийг хүргүүлдэг.

4.2 Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчдад суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, график, үр дүн
- Зөвлөх багш, сургалтын туслах ажилтан, сургалтын менежер, арга зүйч, байрны багш, эмч, сэтгэл зүйч нарын үйлчилгээний чанарын үнэлгээ, сайжруулалт
- Бие хүний төлөвшил, харилцаа, ёс зүйн /зан үйл, зөрчил шийдвэрлэх, эрүүл аж төрөх г.м/ чиглэлүүдээр сургалт явуулж, ур чадвар олгодог байдал
- Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлыг үнэлдэг байдал
- Суралцагч, төгсөгчдөд хөдөлмөрийн биржийн үйлчилгээ үзүүлдэг байдал
- Суралцагчийн судалгаа, шинжилгээний үйл ажиллагааг дэмжин тусласан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Мэдээлэл, Компьютерийн ухааны тэнхимийн бэлтгэдэг хөтөлбөр тус бүрээр оюутнуудад зөвлөх, туслах үйлчилгээ үзүүлэх зорилгоор сургуулийн захирлын тушаалаар зөвлөх багшийг томилон ажиллуулдаг.
- Оюутны ёс зүйн зөрчлийг шийдвэрлэхдээ МУИС-ийн багш, ажилтан, суралцагчийн ёс зүйн дүрмийг удирдлага болгон баримталдаг.
- 2015 оноос эхлэн “Хувь хүний хөгжлийн” сертификаттай сургалтыг МУИС-ийн оюутны албанаас тогтмол зохион байгуулсан.
- Оюутны албаны төсвөөс оюутны санаачилгаар хувь хүний хөгжлийн төслүүдийг дэмжих, санхүүжүүлэх чиглэлийг баримталж ажилладаг.
- Оюутны албанд ирсэн тэтгэлэгт хөтөлбөрүүдэд тэнцэх шалгуур үзүүлэлтэд сайн дурын ажил, нийгмийн идэвхийг чухал байр суурийг эзэлдэг
- Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих уулзалт, сургалт зөвлөгөө, ажил олгогч байгууллагуудтай танилцах аялал, үндэсний бизнесийн байгууллагуудтай хамтран ажиллах санамж бичиг, гэрээ байгуулах зэрэг ажлыг зохион байгуулсан. Мөн оюутныг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах, шаардлагатай хууль эрх зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлсэн байна.
- МУИС-д сайн суралцаж, эрдэм шинжилгээ, судалгаа, олон нийтийн ажилд амжилт гаргаж буй оюутнуудын сурах бололцоог хангах, тэднийг дэмжих

зорилгоор гадаад, дотоодын олон байгууллага, хувь хүмүүс тэтгэлэг олгодог. Эрдэм шинжилгээний ажилд амжилт гаргасан оюутанд МУИС-ийн эрдмийн зөвлөлийн нэрэмжит тэтгэлэг олгох журамд заасны дагуу олгодог.

Зөвлөмж:

- Зөвлөх багшийн үйл ажиллагааг SiSi системд нэмэх

4.3 Оюутны байгууллагад үзүүлэх дэмжлэг

Оюутны байгууллагаас санаачилсан нийгэмд үзүүлэх үйлчилгээг дэмжин хамтран ажилладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Оюутны сайн дурын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, дэмжсэн байдал
- Оюутны байгууллагын үйл ажиллагааг явуулах төсөв, клубын үйл ажиллагааг дэмжих санхүүжилттэй байх, зориулалтын дагуу зарцуулдаг байдал
- Оюутны байгууллагын зүгээс санхүүгийн зарцуулалтаа ил тод тайлагнадаг байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутны албанаас МУИС-ийн оюутны клуб, оюутны холбоо, оюутны байгууллагуудын санаачлан хэрэгжүүлэх төсөл сонгон шалгаруулж төсвөөс санхүүжүүлдэг. Үүнд нийт 19 төслийг 35 сая төгрөгөөр санхүүжүүлсэн байна.
- Оюутны байгууллагын зүгээс санхүүгийн зарцуулалтыг ил тод тайлагнадаг.

4.4 Суралцагчийн урамшууллын тогтолцоо

Суралцагчдын амжилтыг хөхүүлэн дэмжих урамшууллын системтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Урамшуулал, тэтгэлэг хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчдын тоо
- Суралцагчдын үзүүлсэн амжилтууд
- Сургуулиас үзүүлж буй урамшуулал, дэмжлэг

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн нэрэмжит тэтгэлэгт МКУТ-аас жил бүр 1-2 оюутан хамрагддаг ба 2017-2018 оны хичээлийн жилд нэг оюутан хамрагдаж сургалтын төлбөрийн 75%-ийн тэтгэлэг авсан.
- Хүний хөгжлийн сангаас 2531 оюутан, 640539900 төгрөгийн тэтгэлэгт хамрагдсан.

Анхаарах асуудал:

- Сургуулийн кредитын урамшуулал, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах оюутны

тоог нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- Бүрэлдэхүүн сургууль бүрт ялгаатай хувь ноогдуулбал зүгээр

4.5 Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэсэн байдал
- Шилжилт хөдөлгөөний судалгаа, дүгнэлт
- Шилжилт хөдөлгөөнийг зохицуулж буй дүрэм, журам, гэрээний хэрэгжилт, суралцагчийн эрх ашгийг дээдэлсэн байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх дүрэм журмын дагуу суралцагчийн эрх ашигт нийцүүлэн шийдвэрлэдэг.
- 2016 оноос хойшхи шилжилт хөдөлгөөний судалгаанд сургуулиас гарсан буюу өөр хөтөлбөрт 5 оюутан, гадны сургуулиас шилжиж ирсэн 3 оюутан, ХШУИС хүрээнд өөр хөтөлбөрөөс шилжин ирсэн оюутны тоо 2 байна.
- МУИС-ийн 2015.01.14-ны тушаалаар шинэчлэн батлагдсан “Суралцагч шилжүүлэн суралцуулах журам”-аар зохицуулагддаг.
- Багц цагийг 2015.01.14-ны тушаалд зааснаар өөр сургуулиас шилжиж ирж буй суралцагчдыг МУИС-д баримталдаг багц цагийг үндэслэн бүхэл багц цагт шилжүүлэн тооцдог.

Анхаарах асуудал:

- Шилжилт хөдөлгөөний шат дамжлагыг цөөрүүлэх

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

5.1 Багшийн сонгон шалгаруулалт, албан тушаал, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлого: тушаал, урамшууллын бодлого

- Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна. сонгон шалгаруулалт, хөгжүүлэлт, төлөвлөлт, хэрэгжилт
 - Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин
 - Багш суралцагчдын тооны зохистой харьцаа
 - Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагыг мөрддөг байдал
- Гүйцэтгэлийн болон чанарын үнэлгээнд суурилан багш нарыг урамшуулдаг байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш сонгон шалгаруулахдаа 2012 оны 652 тоот тушаал болон шинэчлэн баталсан 2014 оны 414 тоот “Монгол Улсын Их Сургуульд профессор, багш ажиллуулах журам”-ыг баримтлан ажилладаг.
- Багшлах боловсон хүчнийг хөгжүүлэх ажлыг сургалт заах арга, эрдэм шинжилгээ, хувь хүнийг хөгжүүлэх гэсэн чиглэлүүдээр хийж ирсэн. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих ажлын хүрээнд бүтээлээ хэвлэх нийтлүүлэхэд туслах, материаллаг орчныг хангах, докторантурт суралцах сургалтын төлбөрт хөнгөлөлт үзүүлэх, судалгааны ажил хийхэд нь дэмжлэг үзүүлэх, тэтгэлэг өгөх, урамшуулах зэрэг олон арга хэлбэрээр боловсон хүчнээ хөгжүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлж байна.
